



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ахмад настны үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 11,980,000.00 /арван нэгэн сая есөн зуун наян мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000045



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 11-ий өдрийн
...45 дугаар тогтоолын хавсралт

Ахмад настны үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Бонго, 42-90 УНТ, арал № KN3HNP6N35K050375	2005/ 1998	356000	9,980,000.00	9,980,000.00	0	0	500,000.00	125,000.00
2	Комби, 85-46 ТӨА, арал № KN2DAM2C1XK009010	1999/ 2010	16507	2,000,000.00	2,000,000.00	0	0	500,000.00	125,000.00
	Нийт дүн			11,980,000.00 /арван нэгэн сая есөн зуун наян мянган/	11,980,000.00 /арван нэгэн сая есөн зуун наян мянган/	0	0	1,000,000.00 /нэг сая/	

ТАНИЛЦУУЛГА

Ахмад настны үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 11,980,000.00 /арван нэгэн сая есөн зуун наян мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрлийг яамаараа уламжлуулан 2019 оны 03/3635 дугаар албан бичгээр хандан хүссэн юм.

Дуудлагаар худалдах автомашин нь 2005 онд ашиглалтад орсон одоогийн байдлаар эвдрэл, гэмтэл нь хөдөлгүүр цохисон, үндсэн рам хугархай, хурдны хайрцаг бүх араанууд элэгдсэн, жолооны механизм ажиллагаагүй болсон. Гадаад өнгө үзэмж муу, гагнуур авах боломжгүй болсон байна. Цахилгаан доголдолтой. Цаашид авто замын хөдөлгөөнд оролцох болон ашиглахдаа их засвар хийх шаардлагатай.

Энэ талаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн болон Техникийн комиссын дүгнэлт тус бүрд нь гарсан байна.


Худалдах доод үнийг балансын өртгөөс элэгдлийг нь хасч сэргээн засалтын өртгийг нэмж, зах зээлийн ханштай харьцуулан тогтоолоо.

Иймд Ахмад настны үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 11,980,000.00 /арван нэгэн сая есөн зуун наян мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий Бонго маркийн 42-90 УНТ, Комби маркийн, 85-46 ТӨА улсын дугаартай 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах саналыг оруулж байна.

Хуралдаанаас гарах шийдвэрийн /тогтоолын/ төслийг хавсаргав.

Хянасан:


Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн



Д.Нарангэрэл

Боловсруулсан:

Төрийн өмчийн бүртгэл, хяналтын
хэлтсийн мэргэжилтэн



Э.Дуламсүрэн

2020-02-10